

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙ НУУРЫН АГНУУРЫН ЗАГАСНЫ НӨӨЦИЙГ СУДАЛСАН ДҮН

О.Оюунтуяа, Н.Эрдэнэцогт

ХААИС, Экологи, технологи хөгжлийн сургууль

argal8285az@yahoo.com

ХУРААНГУЙ

Дэлхийн зах зээлд цэнгэг нуур, голын загас нь үнэтэй ховор бүтээгдэхүүний нэгд тооцогддог учир сүүлийн жилүүдэд манай оронд гол нуурын загасыг хулгайгаар болон зүй бусаар их хэмжээгээр олборлон дотоодын зах зээлтэй харьцуулахад өндөр үнээр БНХАУ-руу экспортлож байна [2].

Монгол орны усан сангийн 3 ай савд тархсан гол мөрөн, нуур цөөрмийн ус нь байгаль цаг уурын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн нөлөөгөөр багсч түүний био нөөцийн хэмжээ жилээс жилд хомсдсоор байна [1].

ТҮЛХҮҮР ҮГ: Нас, өсөлт, тоо толгой

ОРШИЛ

Архангай аймагт орших Өгий нуур нь далайн түвшинээс дээш 1337 метрт өргөгдсөн. Нуурын урт нь 7.4км, өргөн нь 5.3км, дундаж гүн нь 5.9м хамгийн их гүн нь 19м, нийт 25.1км талбайтай бөгөөд бороо цас

гүний ус зэргээр тэжээгддэг. Өгий нуур нь хойд мөсөн далайн ай савд багтдаг. Энэ нуурт 266-н зүйл ургамал, 20-н зүйл хөхтөн, 3-н зүйл мөлхөгч, 1 зүйл хоёр нутагтан, 129-н зүйл шувуу, 15-н зүйлийн загас, 83 зүйл усны шавж байдаг [1].

ҮНДЭСЛЭЛ

«Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчныг хамгаалах тухай» Рамсарын конвенцийн хавсралт жагсаалтад Монголын хэд хэдэн газар багтсан. Тэдгээрийн нэг Өгий нуур 1998 онд Рамсарын конвенцид бүртгэгдсэн. Монгол орны гол мөрөн, нууруудад 74н зүйл загас тархан суурьшсан бөгөөд тэдгээрийн ихэнхи нь агнуурын ач холбогдолтой. Манай улсад загас агнуурыг жилд дунджаар 180 хоног гүйцэтгэж, улсын хэмжээнд 600 тн загас олборлох боломжтойг Биологийн хүрээлэнгийн эрдэмтэд тооцоолсон байна. Олборлолтыг Буйр нуураас 58.6%, Цагаан нуураас 30.1%-, 11.3%-иар Өгий нуураас тус тус олборлож байна[3]. Өгий нуурын талбайн хэмжээ, усны түвшин жилээс жилд багассаар байгаа нь түүнд амьдрах гидробионт болон зүйлийн бүрэлдэхүүнд сөрөгөөр нөлөөлж байна. Үүнтэй холбогдуулан 2006 оны 04-р сарын 26нд Өгий нуурыг хамгаалалтанд авсан[1]. Иймээс Өгий нуурын

биомасс түүний нөөцийн асуудалд судалгаа шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай юм.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Өгий нуурын агнуурын ач холбогдол бүхий загасны тоо толгой, нөөцийн асуудалд үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Энэхүү зорилгоо хэрэгжүүлэх үүднээс доорхи зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Өгий нуурын загасанд биоанализын судалгаа хийх;
2. Нуурын загасны зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох;
3. Өгий нуурын агнуурын загасны биологийн зарим судалгааг хийх; (өсөлт, идэш тэжээл, нас, хүйс);
4. Өгий нуурын загасны экосистемд үнэлэлт өгөх;

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


Судалгааг хээрийн болон лабораторийн нөхцөлд явуулсан юм. Судалгааны ажилд заламгайн тор, ёроолоос дээж авагч, жин, метр, хайч, хутга, бинокуляр зэрэг багаж хэрэгсэлүүдийг ашиглав.

1. Өгий нуурын Хөгшин Орхон, Хойд мэргэн шанааны цуггал газруудад 20:20мм, 30:30мм,40:40мм хэмжээ бүхий нүдтэй

2. Жижиг загасыг нуур, гол түүний эрэг хэсгээр ёроолын хамагч тор ашиглан цуглуулсан бөгөөд 7-8% --н формалины уусмалд бэхжүүлэв.
3. Загасны насыг тодорхойлох зорилгоор заламгайн хавтасыг авч тусгайлан бэлтгэсэн дугтуйнд хийж лабораторийн нөхцөлд шинжлэхээр хадгалав. \ Н.И.Чугунов. 1959 боловсруулсан арга зүйн дагуу\

СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Өгий нуураас судалгаанд хамрагдсан n=214 загасны зүйлийн бүрэлдэхүүнийг /2011, 2012 оны 6 сар/ 1-р зурагт үзүүлэв.



1-р зураг. Өгий нуураас судалгаанд хамрагдсан загасны харьцаа

Судалгааны явцад 5 зүйлийн n=214 ширхэг загас хамрагдсанаас Алгана (*Perca fluviatilis*) 52%, Улаан нүдэн (*Rutilus Rutilus*) 36%, Цурхай (*Esox Lucius*) 5%, Цулбуурт (*Silurus asotus*) 3% , Бух сурас 4% (*leuciscus*


idus) тус тус эзлэж байв. Судалгаанд хамрагдсан n=214 загасны ходоодон дахь тэжээлийн бүрэлдэхүүнийг 2-р зурагт үзүүлэв.



2-р зураг. Судалгаанд хамрагдсан загасны идэш тэжээлийн харьцуулалт

Судалгааны явцад 5 зүйл 214 ширхэг загасны ходоодон дахь тэжээлийг судлахад Шаамий *gammarus lacustris* 52%, Улаан нүдэнгийн жарамгай *Rutilus Rutilus sigolitca* 1%, Шанаганцар 4%, Сонын авгалдай *odatato* 4%, Ургамал *plants* 3%,

Хоовгон *Trichoptera* 5%, Хоол тэжээл идээгүй *no food* тус тус эзлэж байлаа. Судалгаанд хамрагдсан n=214 загаснуудын насны харьцааг 3-р зурагт үзүүлэв.



3-р зураг. Судалгаанд хамрагдсан загасны насны эзлэх хувь

Дээрх зурагаас харахад 4, 5, 6 настай загаснууд бидний судалгаанд ихэнх хувийг эзлэн хамрагдсан байна. Энэ нь Өгий нуурийн загасны зүйлийн

бүрэлдэхүүн нь залуу загаснууд зонхилж байгааг харуулж байна. Судлагдсан 5 зүйлийн n=214 загасны хүйсийн харьцааг 4-р зурагт үзүүлэв.



4-р зураг. 5 зүйлийн загасны эр, эм хүйсийн харьцаа

Судалгаанд хамрагдсан n=214 загаснаас 115 ширхэг буюу 54.2%-ийг эм, 99 ширхэг буюу 45.8%-ийг эр

бодгаль эзлэж байв. Өгий нуурын агнуурын загасны зүйлийн бүрэлдэхүүнийг 5-р зурагт үзүүлэв.



5-р зураг. Загасны зүйлийн бүрэлдэхүүнийг оноор харьцуулсан байдал

Өгий нуурын агнуурын загасны зүйлийн бүрэлдэхүүн 2000 онд 17 зүйл, 2005 онд 14 зүйл, 2011, 2012 оны 6 сард хийсэн бидний судалгаагаар 5 зүйл загас

судлагдав. Энэ нь агнуурын ач холбогдол бүхий загаснуудын тоо толгой, зүйлийн бүрдэл буурч байгаа үзүүлэлтийг харуулж байна.

ШҮҮН ХЭЛЭЛЦЭХҮЙ

Өгий нуурт 2005-2006 онд хийсэн /ЛІСА/ олон улсын байгууллагын судлаачдын явуулсан судалгааны дүнтэй, бидний 2011, 2012 оны 6 сард хийсэн судалгааны үр дүнг харьцуулав. Өгий нуурт 2005 оны 6 сард хийсэн судалгаагаар 14 зүйл, 2006 онд мөн энэ сард хийгдсэн ажлаар 13 зүйл загас судлагдсан байхад 2011, 2012 оны 6 сард явуулсан бидний судалгаанд 5 зүйл загас хамрагдлаа. Эндээс харахад загасны зүйлийн бүрэлдэхүүн 5-6 жилийн хугацаанд 8-9 зүйлийн загасаар багассан баримт харагдаж байна. Гэхдээ энэ харьцуулалтыг эцэслэн батлахад улиралын шинжтэй 5-10 жилийн судалгаа чухал юм.

2005 онд судлаач Г.Баасанжавын судалгаагаар 110 см урт, 9100 гр жинтэй 7+настай цурхай тэмдэглэгдсэн байхад, 2012 онд хийсэн бидний судалгаанд 87.5см урт, 6300 гр жинтэй 7+настай цурхай судлагдсан юм. Энэ нь нуурын идэш тэжээлийн хэмжээ ховордож буй үзүүлэлттэй холбоотой байж болох юм.

ДҮГНЭЛТ

1. Бидний судалгааны явцад /2011-2012 оны 6 сард/ 5 зүйл загас хамрагдсаныг 2005-2006 сард хийсэн судалгаатай харьцуулахад зүйлийн бүрэлдэхүүний тоо 7-8 зүйлээр багассан үзүүлэлт харагдаж байна.
2. Загасны насны бүтцийг харахад агнуурын насны, залуу бодгалиуд 60 хүртлэх хувийг эзэлж байв.
3. Загасны хүйсийн харьцаа эм 53,2, эр 46,8 гэсэн хувьтай байгаа нь хүйсийн харьцаа байгальд байх

зүй тогтолоосоо хэлбэлзэх хандлагатайг харуулж байна.

4. Өгий нуурын биомассын хэмжээ жилээс жилд багсаж байгаа нь дулаарал, хүний буруутай үйл ажиллагаа, хэт их агналт, хууль бус олборлолт зэрэгтэй шууд хамааралтай юм. Иймээс монгол орны гадаргын усны нөөцийг хамгаалахын тулд түүний нөөцийн болон биомассын асуудалд анхаарч системчилсэн ажлуудыг хийх хэрэгтэй байна.

НОМ ЗҮЙ

1. "Өгий нуурын экосистемийг хамгаалах төслийн 2006 оны судалгааны ажлын тайлан." УБ., 2007 он
2. ХААШУ танин мэдэхүйн сэтгүүл, №5 \ху-102\ УБ., 2010
3. "Төвийн бүс нутгийн уур амьсгалын нөөц, түүний өөрчлөлт" УБ., 2007.
4. Баасанжав. Г., Цэнд аюуш.Я., "Монгол орны загас" УБ., 2001.
5. Дашдорж.А., Цэндсүрэн.А., Дулмаа.А., "Монгол орны усны амьтадыг тодорхойлох түлхүүр" 1970.
6. Ососк.Ј.,бусад., "Монгол орны загасны улаан данс"
7. Цэрэнсодном.Я., Монгол орны нуурын цэс" 2000
8. Ососк.Ј.,бусад., "Монгол орны загас хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл".
9. /ЖАЙКА/ олон улсын байгууллагын тайлан 2008 он

ABSTRACT

Because freshwater and river fishes are believed as one of valuable and rare products in worldwide markets, much freshwater fishes are caught by poaching or illegal ways in our country for the last years and they are exported to China for higher prices. Several areas in Mongolia were included in the annex list of Ramsar convention on wetlands of international importance. One of them is Ugii lake, registered in Ramsar convention in 1998. Fishes of 74 species are distributed in rivers and lakes in Mongolia and majority of them are of fishery importance. According to estimation of scientists of Institute of biology, fishing is active for 180 days in average a year and totally 600 tonn fish can be caught in our country.

However, decrease of biomass in Ugii lake from year to year is directly associated with warming, improper actions of humans, overfishing and illegal fishing. Therefore it has been essentially important to pay attentions on water resource and biomass issues and implement organized activities in order to protect surface water resources in Mongolia.